

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2023.04.05

№ 23/28

Улаанбаатар хот

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл
байгуулах зөвшөөрөл олгох тухай**

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.7, 89, 91,92,93 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9, 33 дугаар зүйлийн 33.5, “Богд Банк” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.14.27 дах хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит бус хурлаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэсэнээр ТОГТООХ нь:

1. “Бодь Цамхаг” ХХК “Богд Банк” ХК нарын хооронд хийгдэх түрээсийн гэрээнүүдийг энэхүү тогтоолын хавсралтаар баталж сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцсугай.
2. Энэхүү хэлцлийг “Богд Банк” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн сонирхлын зөрчилгүй нийт гишүүд (хараат бус гишүүнийг оролцуулаад)-ийн дийлэнх олонхийн саналаар байгуулсугай.
3. Хавсралтаарх гэрээг байгуулахыг Гүйцэтгэх Захирал /Г.Саруул/-д зөвшөөрсүгэй.
4. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг байгуулахтай холбоотой холбогдох тайлан мэдээлэлд тусгаж холбогдох хууль тогтоомжид заасан мэдээлэх үүргийн хэрэгжилтийг хангуулахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Р.Нямцэрэн/-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Дотоод Аудитын Газар (Д.Төрмандах)-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ